

**“ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 10 дугаар сарын 01

Багануур дүүрэг

№	Үйл ажиллагааны чиглэл	Гүйцэтгэх ажил үйлчилгээ	Гүйцэтгэл	Хувь
Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гүйцэтгэл				
2.2.1. Зорилт 1. Дүүргийн хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөв, төлөвлөгөө, хяналт шинжилгээнд жендэрийн мэдрэмжтэй арга зүй нэвтрүүлэх, төр, хувийн хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжийн ажилтнуудын жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх				
Хүрэх үр дүн: Дүүргийн төрийн албан хаагч, ААНБ-ын удирдлага, ажилтнуудын жендэрийн талаарх ойлголт мэдлэг нэмэгдэж, хандлага өөрчлөгдөн бодлого төлөвлөлт, төсөв жендэрийн мэдрэмжтэй болно.				
1	Жендэрийн талаар мэдлэг олгох сургагч багш нарыг бэлтгэж, байгууллага, ААН-ийн удирдлага, төрийн албан хаагчдад зориулсан жендэрийн танхимын болон цахим сургалтанд хамруулах	Жендэрийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулагдах бүрт байгууллагын албан хаагчдыг идэвхтэй хамруулах	2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Төрийн захиргааны удирдах ажилтнуудад зориулсан “Жендэр ба хүний эрх” сэдэвт сургалтад Маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн оролцсон. Одоогоор өөр сургалт зохион байгуулагдаагүй байна.	100%
2	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендэрийн дүн шинжилгээ хийх, төсвийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, үнэлэх сургалтанд төсвийн мэргэжилтэн, санхүүгийн албан хаагчдыг хамруулах	Санхүүгийн албан хаагчийг төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендэрийн дүн шинжилгээ хийх, төсвийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, үнэлэх сургалтанд идэвхтэй хамрагдахад нь анхаарч, дэмжлэг үзүүлэх	Уг сэдвийн дор одоогоор сургалт зохион байгуулаагүй байна. Санхүүгийн холбогдолтой зохион байгуулсан сургалтад Нягтлан бодогч хамрагдсан.	100%
3	Төрийн байгууллагын ажиллагсдын Ажил – ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлал, бэлгийн дарамтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх талаар байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлэх	Албан хаагчдын ажил - ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлал, бэлгийн дарамтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх талаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган, хэрэгжилтийг хангах	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд тусгах төслийг боловсруулж байна.	50%
2.2.2. Зорилт 2. Гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх				

Хүрэх үр дүн. Иргэдийн дундах жендерийн талаарх хэвшмэл ойлголт өөрчлөгдөж жендерийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдал багасна.				
4	Ажил олгогч нь ажилтны гэр бүлийн байдалд судалгааг хийж, ар гэрийг тохиромжтой хэлбэрээр дэмжиж, хорт зуршил бүхий ажилтныг эрүүл амьдралын зөв дадал хэвшилд шилжихэд дэмжсэн орчин бүрдүүлэх	Албан хаагчдын гэр бүлийн байдалд судалгаа хийж тохиромжтой хэлбэрээр дэмжлэг үзүүлэх	Корона вирусын халдвартай холбогдуулан хүн амыг олноор цуглуулахгүй байх үүднээс Олон улсын хүүхдийн баяр буюу Монгол улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг 2019.05.29-ний өдөр зохион байгуулан албан хаагчдад хүүхдийн бэлэг болон баярын тортыг гардуулан өгсөн. Байгууллагын жолооч Н.Жаргалсайханы гэр бүлд эмнэгэл гачигдал тохиолдсон ба 5 хоногийн цалинтай чөлөө олгон, хамт олны зүгээс сэтгэлийн хандив өгч дэмжлэг үзүүлсэн.	100%
2.2.4. Зорилт 4. Дүүргийн жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоог нэмэгдүүлэр замаар хүний хөгжлийг дэмжих				
Хүрэх үр дүн. Салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирч жендерийн эрх тэгш байдал хангагдана.				
5	Ажил олгогчийн зүгээс иргэдийг ажилд авах, албан тушаал дэвшүүлэхэд эрэгтэй хүнийг илүүд үзэх хэвшмэл ойлголтыг арилгах, эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн үүрэгтэй нь холбогдуулан ялгаварлахгүй байх, тухайн байгууллагад цөөн тоотой хүйсийн хүнийг сонгох замаар хүйсийн тэнцвэрт байдлыг хангах	Ажил олгогчийн зүгээс жендерийн эрх тэгш байдлыг ханган ажилд авах	2020 оны 01 дүгээр сард 1 эрэгтэй, 1 эмэгтэй ажилтныг холбогдох албан тушаалд томилон одоогийн байдлаар 6 эр, 6 эм нийт 12 ажилтантайгаар Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь жендерийн эрх тэгш байдлыг ханган ажиллаж байна.	100%

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч. ЭЛБЭГСАЙХАН



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТНИЙ
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э. ЭНХЗАЯА